



Ажлын удирдамж

Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийг зохион байгуулалтад оруулах, албажуулах, бичил уурхайчдын байгууллагыг чадавхжуулахад орон нутгийн иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах

Ажиллах аймаг: Завхан, Өмнөговь, Өвөрхангай, Ховд, Хэнтий

Ажиллах хугацаа: 7 сар: 2017 оны 5 дугаар сараас 12 дугаар сар хүртэл

1. Үндэслэл

Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Швейцарийн Холбооны Улсын Гадаад хэргийн яамны харъяа Швейцарийн хөгжлийн агентлагийн хамтран хэрэгжүүлж буй Тогтвортой бичил уурхай төслийн 4 дэх үе шат 2015 оноос эхлэн амжилттай хэрэгжиж байна.

Төслийн энэ үе шатны зорилго нь эдийн засгийн хувьд тогтвортой, байгаль орчны хариуцлагатай, хүний эрхэд суурилсан Монгол Улсын бичил уурхайн салбарыг төлөвшүүлэх, бичил уурхайгаар олборлосон алтны худалдааны эрх зүйн орчныг бүрдүүлэх, нийлүүлэлтийн сүлжээг албажуулах, бичил уурхайн талаарх дэлхийн бусад орны сайн туршлагаас суралцах, өөрсдийн туршлагаас хуваалцахад дэмжлэг үзүүлэх явдал юм.

Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийг зохион байгуулалтад оруулах, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг таниулан, сурталчилах, бичил уурхайг албажуулах үйл явцыг орон нутгийн төрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэхэд орон нутгийн иргэний нийгмийн байгууллагуудын үүрэг оролцоо чухал байгаа юм.

Иймд төслийн зүгээс 2017 онд Ховд, Хэнтий, Өмнөговь, Завхан, Өвөрхангай зэрэг аймагт орон нутгийн иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах ажлын удирдамжийг боловсруулж байна.

2. Ажлын зорилго

- Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдэд бичил уурхайн холбогдох хууль эрх зүйн мэдлэг мэдээлэл олгох, зохион байгуулалтанд орсны ач холбогдолыг таниулах
- Зохион байгуулалтанд ороод үйл ажиллагаа эхэлсэн БУ-н нөхөрлөлүүд болон төрийн бус байгууллагуудыг чадавхжуулах
- Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийг бичил уурхайн зохион байгуулалтад оруулах, бичил уурхайг албажуулах явцыг эрчимжүүлэх талаар орон нутгийн төрийн байгууллагуудтай хамтран ажиллах

3. Ажлын нэр

Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийг зохион байгуулалтад оруулах, албажуулах, бичил уурхайчдын байгууллагыг чадавхжуулах ажлыг гүйцэтгэх орон нутагт тогтвортой үйл ажиллагаа явуулж буй иргэний нийгмийн байгууллагыг сонгон шалгаруулах

Дээрх 5 аймаг тус бүр нэг иргэний нийгмийн байгууллагыг сонгон шалгаруулж, 2017 оны 5 сараас 12 сар хүртэлх хугацаанд буюу 7 сарын турш Тогтвортой бичил уурхай төсөл (ТБУТ) гэрээ байгуулж хамтран ажиллана.

Иргэний нийгмийн байгууллага нь дараах үйл ажиллагааг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Бичил уурхайн эрх зүйн орчин, зохион байгуулалтад орохын ач холбогдлыг таниулах, сурталчилах, сургалт зохион байгуулах (аймаг тус бүрт 800-1000 хувиараа ашигт малтмал олборлогч иргэд болон бичил уурхайчдад хүрч ажиллана);
- Бичил уурхайн нөхөрлөл, хоршоо, ТББ-уудын чадавхыг бэхжүүлэх сургалтуудыг зохион байгуулах (байгууллагын дотоод зохион байгуулалт, шийдвэр гаргахад гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх, удирдах болон хяналтын зөвлөлийн гишүүдийн чадавхыг бэхжүүлэх, санхүүгийн менежментийг сайжруулах, гэх мэт);
- Хүний эрхэд суурилсан хандлага, жэндэрийн тэгш байдлын талаар тухайн аймгийн Хүний эрхийн Үндэсний Комиссын ахлах мэргэжилтэнтэй хамтран бичил уурхайчдад сургалт зохион байгуулах;
- Бичил уурхайн үйл ажиллагаатай холбоотой орон нутгийн төрийн байгууллагуудтай нягт хамтран ажиллах, сард нэг удаа хамтарсан уулзалт зохион байгуулах;
- Аймгийн хэмжээнд хувиараа ашигт малтмал олборлогч иргэд, бичил уурхайчдын нарийвчилсан судалгаа, мэдээллийг цуглуулан мэдээлийн сан үүсгэх, Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо (МБУНДХ)-той хамтран ажиллах;

Сонгосон 5 аймагт доорх бичил уурхай бүхий сумдад хүрч ажиллана.

1. Завхан аймаг: Завханмандал, Ургамал, Дөрвөлжин, (Улиастай) сумд
2. Ховд аймаг: Алтай, Үенч, Булган, Мөст, Дөргөн, Цэцэг сумд
3. Хэнтий аймаг: Батноров (Бэрх тосгон), Норовлин, Баян-Адарга, Бор-Өндөр, Дархан, Хэрлэн сумд
4. Өвөрхангай аймаг: Уянга, Бат-Өлзий, Баруунбаян Улаан, Нарийнтээл сумд
5. Өмнөговь аймаг: Цогт-Овоо, Баяндалай, Сэврэй, Гурвантэс, Ноён, Баян-Овоо сумд

4. Хүлээгдэж буй үр дүн

- Хувиараа ашигт малтмал олборлогч иргэд бичил уурхайн холбогдох хууль эрх зүйн мэдлэг мэдээллээр хангагдан зохион байгуулалт орсон байна. Бичил уурхайн байгууллагуудын гишүүд өөрсдийн эрх шаардах мэдлэг чадавхтай болсон байна. Аймаг тус бүрт бичил уурхайн байгууллага, бичил уурхайчдаас 10-аас доошгүй өөрсдийн эрхээ шаардсан албан тоотыг холбогдох төрийн байгууллагад гаргасан байна. Тухайлбал: Хөдөлмөрлөх эрх – газрын асуудлаа шийдвэрлүүлэх, эрүүл аюулгүй орчин хөдөлмөрлөх, эрүүл мэндийн үйлчилгээ авах, нийгмийн үйлчилгээ авах талаар гэх мэт.
- Аймаг тус бүрт 800 – 1,000 хувиараа ашигт малтмал олборлогчид болон бичил уурхайчдад хүрч ажилласан байна.
- Аймаг тус бүрт багадаа 2-оос доошгүй бичил уурхайн байгууллагууд байгуулагдаж, ХАМО иргэд зохион байгуулалтанд орж, албажсан байна.
- Аймгийн төвшинд бичил уурхайчдын мэдээллийн санг үүсгэн, Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо (МБУНДХ)-той хамтран ажилласан байна.
- Хүний эрхэд суурилсан хандлага, Жендэрийн эрх тэгш байдлын талаар оролцоогч талуудын мэдлэг дээшилсэн байна.
- Бичил уурхайн талаар эерэг ойлголтыг олон нийтэд бий болгосон байна.

5. Иргэний нийгмийн байгууллагад тавигдах шаардлага

- Орон нутгийн түвшинд өргөн хүрээний хөгжлийн үйл ажиллагааг чиглүүлэн явуулж байсан 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай, тухайн аймагт тогтвортой үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллага байх;
- Нутгийн иргэдтэй ажиллах, тэднийг хөгжүүлэх, чадавхыг бэхжүүлэх, байгууллагын дотоод зохион байгуулалт, санхүүгийн менежментийн талаар сургалт зохион байгуулах ажлын туршлагатай байх;
- Иргэний нийгмийн байгууллага нь сайн засаглал, хүний эрх, жендэрийн тэгш байдал, хамтын оролцооны аргын талаар тодорхой ажлын туршлагатай байх;

- Хувиараа ашигт малтмал олборлогч иргэд, бичил уурхайчидтай ажиллаж байсан туршлагатай бол давуу талтай;
- Иргэний нийгмийн байгууллага нь тухайн аймгийн Хүний эрхийн Үндэсний Комиссын ахлах мэргэжилтэн, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Онцгой байдлын газрын мэргэжилтнүүдтэй нягт хамтран ажиллах чадвартай 2 хүний бүрэлдэхүүнтэй багийг томилж ажиллуулах;
- Үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа стандартын дагуу боловсруулах чадвартай байх;
- Оффисын тоног төхөөрөмжтэй байх (компьютер, принтер, хувилагч машин гэх мэт);

6. Тайлагнах

Сонгогдсон иргэний нийгмийн байгууллага нь сар бүр Тогтвортой бичил уурхай төсөлд үйл ажиллагааны явцын тайлангаа өгнө. Тайлан бичихдээ ТБУТ-өөс өгөх тайлангийн загварыг ашиглана. Санхүүгийн тайланг хоёр сар тутам гаргаж ТБУТ-д ирүүлнэ.

7. Хяналт, үнэлгээ

Сонгогдсон иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг ТБУТ-ийн холбогдох мэргэжилтнүүд тогтмол хянаж, үнэлнэ. Санхүүгийн зарцуулалтын тайланг төслийн зүгээс цаг хугацаанд нь байнга хянана. ТБУТ-ийн баг сонгосон аймгуудын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай газар дээр нь 1-2 удаа очиж танилцана.

8. Хүний эрхэд суурилсан хандлага, жендерийн тэгш байдлыг хангах тухай

Швейцарийн хөгжлийн агентлаг, Тогтвортой бичил уурхай төсөл хүний эрхэд суурилсан хандлагыг үйл ажиллагаандаа тусгаж ажилладаг. Хүний эрхэд суурилсан хандлага нь хүн бүр эрхээ эдлэх боломжийг Төрийн зүгээс хууль ёсны дагуу баталгаажуулах үндсэн зарчим гэж үздэг. Тогтвортой бичил уурхай төсөл эрэгтэй болон эмэгтэй оролцогчдод ижил боломж олгохыг дэмжиж ажилладаг. Иймд төслийн хамтрагчид Тогтвортой бичил уурхай төслийн гэрээт ажлыг хэрэгжүүлэхэд Хүний эрхэд суурилсан хандлагыг зарчим болгож жендерийн тэгш байдлыг хангаж, жендерийн мэдрэмжтэй үйл ажиллагаа явуулахыг зөвлөж байна.

9. Бүрдүүлэх материал

Шалгаруулалтад оролцох тухайн орон нутгийн иргэний нийгмийн байгууллага нь уг ажил үйлчилгээг гүйцэтгэх ажлын төслийн саналаа боловсруулан дугтуйд хийж битүүмжлэн 2017 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 17.00 цагаас өмнө тухайн аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст ирүүлнэ. Мөн бүх материалын PDF хувийг Тогтвортой бичил уурхай төсөлд ulaanbaatar@sam.mn е-мэйл хаягаар ирүүлнэ үү.

Үүнд:

- Гүйцэтгэх ажлын төслийн санал (байгууллагын танилцуулга, холбогдох ажлын туршлага, гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, багийн гишүүдийн анкет, байгууллагын гэрчилгээ)
- Санхүүгийн санал (хийх ажлын төлөвлөгөөнд үндэслэн санхүүгийн тооцоолол)
- Өмнө нь хийж хэрэгжүүлсэн 3-аас доошгүй ажлын талаарх бусад байгууллагуудын тодорхойлолт

Холбоо барих:

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот
Элчингийн гудамж, 1-р хороо
Скай Плаза бизнес төв
Утас: +976 11-328848-115; 70443724
Вебсайт: www.sam.mn
И-мэйл: ulaanbaatar@sam.mn